



Ч.Санжмятав

Удирдлагын академийн ССЗТ-ийн эрхлэгч, профессор

ОЮУТАН СУРАЛЦАГЧДАД СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ХАРИЛЦАА, МЭРГЭЖЛИЙН ЧАДВАР ТӨЛӨВШҮҮЛЭХ АРГА ЗАМ, ТЕХНОЛОГИ

Abstract : This study attempts to review the research works created by scholars, psychologists and education specialists. It analyzed the teacher`s communication skills, components of communication skills and their development presented in those works, thus it raises hypothesis on several stages of psychological factors of communication skills development.

Key words: habits, abilities, education skills, reflections, relations, attitudes, external and internal factors

Товч агуулга: Энэ өгүүлэлд сэтгэл зүйч, боловсрол судлаач эрдэмтдийн бүтээлд анализ хийж багшийн харилцааны чадвар, түүний бүрэлдэн төлөвших үйл явц, харилцааны бүтцийг авч үзэж, харилцах чадвар төлөвших сэтгэл зүйн хэд хэдэн нөхцөлийг таамаглал болгон дэвшүүлсэн болно.

Судалж байгаа асуудалтай холбоотойгоор багшийн харилцааг тогтоох чадвар, харилцах үйл ажиллагааг судалсан О.А.Абдулина, Г.А.Засобина, К.Елманова, Н.В.Кузьмина, Г.С.Костюк, А.А.Кидрон, Е.А.Милерян, К.К.Платонов, Л.Рубинштейн, Е.Б.Орлова, Б.А.Сластенин, Л.Ф.Спирин, И.В.Страхов, Я.И.Уманский, А.И.Щербаков, нарын зэрэг эрдэмтэн судлаачдын бүтээл [1, 9, 13, 14, 31, 33, 36, 40, 41, 42] бидний сонирхлыг татаж байна. Юуны түрүүнд сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг бүтцийн бүрэлдэхүүн хэсэгт хувааж ангилсан Оросын сэтгэл зүйч Н.В.Кузьминагийн¹ уламжлалт ангиллыг дурдах нь зүйтэй. Үүнд: зохион бүтээх, онол мэдлэгийн, зохион байгуулах, хавсарга болон харилцах гэсэн бүрдлүүд орж

¹ Н.В.Кузьмина. Очерки психологии труда учителя. Л., 1967. с.183, Н.В.Кузьмина, Н.В. Кухаренко. Психологическая структура деятельности учителя (тексты-лекции). -Гомель. 1979. с.57

байна.

А.И.Щербаковын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг судалж ангилсан ангилалд харилцаатай холбоотой дэд бүрдэл байдаг. Түүний бүтээлд сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг зохион бүтээх, зохион байгуулах, мэдээлэх, хөгжүүлэх, баримжаалах, харилцах гэсэн дэд бүрдэлд хувааж ангилсан байдлаас дээрх санаа илэрч байна. А.И.Щербаков багшийн ур чадварын үндэс бол сурган хүмүүжүүлэх чадвар гэж үзээд багшийн их сургуулийн оюутан суралцагчдад түүнийг төлөвшүүлэхийн ач холбогдлыг цохон тэмдэглэсэн байдаг².

Б.А.Сластенины³ санал болгосон сурган хүмүүжүүлэх чадварын талаарх ангиллыг задлан шинжилж үзвэл бид тэндээс дараах харилцааны чадварыг ялган үзэж болно. Үүнд: суралцагчдын идэвх; зан байдлыг удирдах чадвар; суралцагчдын хамт олон, бага бүлэг, тодорхой сурагчтай сурган хүмүүжүүлэх зохимжтой уялдаа холбоо тогтоох чадвар; янз бүрийн нөхцөл байдалд, олон янзын хүмүүстэй зөв өнгөөр ярих, хэл амаа ололцох холбоо тогтоох чадвар; бусдын байр суурин дээр өөрийгөө ухамсарлан тавих чадвар гэх мэт.

Сурган хүмүүжүүлэх харилцаа нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны чухал хэсэг болохынхоо хувьд багшаас сурагчид үзүүлэх нөлөөллийн нийгэм сэтгэл зүйн үндсийг бүрдүүлдэг. Харилцах үйл ажиллагаагаар дамжин түүний бусад бүрдлүүд /зохион байгуулах, зохион бүтээх, танин мэдэхүйн болон бусад/ янз бүрийн байдалтайгаар хэрэгждэг онцлогтой.

Үйл ажиллагааны ямар нэгэн төрөл, багш

² А.И.Щербаков. Психологические основы формирования личности советского учителя в системе высшего педагогического образования. Л.,1967. с. 266

³ Б.А.Сластенин. Формирование личности учителя советской школы в процессе профессиональной подготовки. М., 1976. с.160

суралцагчдын харилцааны процесс багшаас харилцах чадварыг эзэмшсэн байхыг шаарддаг бөгөөд сурган хүмүүжүүлэх чадварын бүрэлдэхүүн хэсэг болдог.

Л.Ф.Спирин чадварыг өөрийнхөө шинж чанараар маш нарийн нийгэм-сэтгэл зүйн бүрэлдэл гэж үзсэн бөгөөд энэ ухагдахууны олон утгат байдал нь зарим судлаачдаас уг чадварыг бие хүний шинж чанар, түүний зан төлөвийн шинжүүдтэй ижилсүүлж ойлгох үндэс суурийг бий болгожээ гэж тэмдэглэсэн байдаг. Энэ ижилсүүлэлтийн үндсэн шалтгааныг Л.Ф.Спирин тодорхойлохдоо, чадвар бол бие хүний сэтгэл зүйн онцлог, түүний зорилго, сэтгэл хөдлөлийн цар хүрээ, чиглэл зорилгот чанар, мэдлэг, анхаарал, бүтээлч сэтгэлгээтэй органик холбоотой гэж үзсэн. Үүнтэй холбогдуулан чадварын мөн чанарын талаарх бидний ойлголт, өөрийнхөө судалгааны ажлын онолын байр суурийг товч тодорхойлох нь чухал юм.

Бие хүний сэтгэл зүйн онцлог, чадвар хоёрын хоорондын диалектик уялдаа холбооны талаарх асуудлыг Н.В. Кузьмина, Е.А.Милерян, К.К.Платонов, Л.Ф.Спирин, А.И.Щербаков болон бусад судлаачдын бүтээлүүдэд тодорхой задлан шинжилсэн байдаг.

Бидний судалгааны ажлын зорилгод нөлөөтэй маш чухал зүйл бол Оросын сэтгэл зүйч К.К.Платоновын гаргасан хүний олж авсан мэргэжлийн чадвар нь түүний бие хүний шинж байдал болдог баталгаа юм⁴. Чадварыг эзэмших үйл нь зөвхөн мэдрэмж хөдөлгөөнөөр хязгаарлагдахгүй, харин оюун ухаан, зориг-сэтгэл хөдлөлийн болон бие хүний мэргэжлийн чухал чанарыг хөгжүүлдэг онцлогтой гэж Е.А.Милерян⁵ үзсэн байхад, сурган хүмүүжүүлэх чадвар бүрэлдэн төлөвшихийн хэрээр бие хүн бүхэлдээ өөрчлөгдөх үйл явцад ордог (тухайлбал, харилцааны тогтолцоо, багшийн зан төлөв, зоригийн шинжүүд гэх мэт) гэж Н.В.Кузьмина, Н.В.Кухаренко нар онцлон тэмдэглэсэн байдаг. Ийм учраас чадвар эзэмших үйл явцад оюутан зөвхөн суралцаад зогсохгүй, харин тэр өөртөө мэргэжлийн чухал чанаруудыг төлөвшүүлдэг. Ер нь хүн ямар нэг чадварыг амжилттай эзэмшихэд, түүний өөрт нь байгаа тодорхой шинж, чанаруудын бүтэц илүүц их нөлөөтэй байдаг. Дээр нэрлэсэн судалгааны бүтээлүүдэд хийсэн анализ, багшлах ажлынхаа явцад ажигласан зүйл дээрээ үндэслэж үзэхэд, сурган хүмүүжүүлэх харилцаанд хамаарах олон төрлийн шинж чанарын дотроос хамгийн тэргүүн зэрэгт нь харилцаа сайтай чанар орж байна. Бие хүний шинж бусад хүнтэй уялдаа холбоо тогтооход хөнгөн, шалмаг, хялбархан байдгаар тодорхойлогдоно. Судалгааны материалаас үзэхэд, эн тэргүүнд хамаарах шинж чанаруудад даруу төлөв байдал, тогтвортой төв

төвшин шинжийг /өөрийгөө удирдах чадвар, тэгш, төвшин харилцааг зохион байгуулах чадвар/ оруулж үзсэн байгаа юм.

Иймээс чадвар гэдэг бол бие хүний шинж чанар, түүний зан төлөв, бие хүнийг бүхэлд нь хамарч маш гүнзгий диалектик уялдаа холбоогоор шүтэлцсэн сэтгэл зүйн нарийн иж бүрдэл мөн.

Багш, суралцагчдын хоорондын харилцааг амжилттай бүтээлч болгох нөхцөл бол бие хүний хувийн сэтгэл зүйн өвөрмөц онцлог юм. Ийм учраас бид багшийн харилцах чадварыг түүнд хамааруулан ойлгожбайна.

Сурган хүмүүжүүлэх авьяасын ерөнхий бүтцэд Н.В.Кузьмина «хүүхдүүдтэй зөв харьцаа холбоо тогтоох түүнийгээ суралцагчдын хөгжил, тэднээс багшид тавьж байгаа шаардлагатай нийцүүлэн өөрчлөх чадварыг»⁶ оруулж харилцах чадвар гэж нэрлэсэн байдаг. Цааш нь З.Ф.Есарев, Н.В.Кузьмина, А.В. Фомин нарын сэтгэл судлаач эрдэмтэд дээрх чадвар сурган хүмүүжүүлэх авьяасын бусад төрлийг нөхвөрлөх чадвартай учраас сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд голлон тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг болохыг дурджээ. Харилцааны авьяас хөгжихөд нөлөө үзүүлдэг харилцах чадвар интеграл шинж чанартай.

А.В.Фомин⁷ судалгааны ажлын үр дүнгээс үзэхэд, сурган хүмүүжүүлэх системийн үйл ажиллагааны дэд бүрдэлд орж байгаа багшийн харилцах чадварын төлөвшлийн түвшнээс сурган хүмүүжүүлэх харилцан үйлдлийн амжилт ихээхэн хамааралтай болох нь илт байна.

Юуны түрүүнд бид судалгааныхаа ажилд харилцах чадварын талаар онолын ойлголт өгөхийн тулд сурган хүмүүжүүлэх чадварын онцлог, үүсэл, ухагдахуунтай холбоотой маргаант асуудлууд дээр ерөнхийд нь тогтож авч үзэх шаардлагатай юм.

“Чадвар”, “Дадал” хэмээх ухагдахууны талаарх сурган сэтгэл зүйн бүтээлүүд, судалгаанаас үзэхэд, зарим нэг судлаачид (Н.Д-Левитов, И.С.Лукин, Е.И.Кабаново-Меллер, К.Н.Корнилов, Цварц болон бусад) дадал бол нэлээд дээд зэргийн бүрдэл бүхий үйлдэл гэж үзсэн байдаг бөгөөд чадварыг үйлдэл эзэмших анхны шатанд хамааруулж, бүрэн төлөвшөөгүй дадал, зөвхөн түүний төлөвших үйлийн нэг шат гэж тодорхойлсон байгаа юм.

Бидний энэ судалгаанд Е.И.Бойко, Л.Б.Ительсон, Г.С.Костюк, А.В.Петровский, К.К.Платонов, В.В. Чебышева болон В.А.Онищук, Л.А.Спирин, А.В.Барабанщиков нарын бүтээлд туссан үзэл санаа ихээхэн сонирхол татаж байгаа билээ. Эдгээр судлаачид, дадлыг бодоход чадвар нь илүү дээд зэргийн бүрдэл, үйлдэл эзэмших үйл

⁴ К.К. Платонов. Вопросы психологии труда. М., 1962. 219с.

⁵ Е.А.Милерян Психология формирования общетрудовых политехнических умений. М., 1979. с.299

⁶ Н.В.Кузьмина. Очерки психологии труда учителя. Л 1967. с.136.

⁷ А.В.Фомин Роль коммуникативных умений в процессе педагогического взаимодействия преподавателя со студентами : Автореф.дисс.канд.пед.наук. Л.,1978. с.17



явцын төгсгөлийн шат гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Бид чадвар нь дадлыг бодоход нэлээд дээд зэргийн бүрдэл гэсэн санааг зөвшөөрч дэмжиж байна. Судлаачид чадварыг тодорхойлсон байдлыг авч үзье. Тухайлбал, Е.А.Милерян, чадварыг мэдлэг, дадалдаа суурилан хувирч буй нөхцөл, үйл ажиллагаанд өөрийнхөө өмнө тавьсан зорилгод хүрэх авьяас⁸ гэж тодорхойлсон байхад, Л.Б.Ительсон «субъект мэдлэг дадалдаа тулгуурлан аливаа үйл ажиллагааг зохицуулах практик болон сэтгэцийн үйлдлийн нарийн тогтолцоо» гэж үзсэн бол Ф.Н.Гоноболин «Үйл ажиллагааны явцад олж авсан мэдлэг, дадалдаа суурилан ямар нэгэн үйлдлийг илүү боловсронгуй гүйцэтгэх арга хэлбэр»⁹ хэмээжээ.

Дээрх тодорхойлолтуудаас харахад чадвар эзэмших процесс нь зорилгодоо захирагдах үйл, дадлаас хамааралтай харагдаж байна. Дашрамд хэлэхэд, судлаачид, ямар нэгэн нөхцөл байдалд шаардлагатай зорилтыг шийдвэрлэхийн тулд ямар замаар /маягаар/ ажиллах, хэрхэн яаж мэдлэг олж авсан байна гэдэг нь онцгой ач холбогдолтой болохыг тод томруун гаргаж өгсөн байгаа юм. Энэ үндэслэлээр Е.А.Милерян чадварыг «үйлдлийн мэдлэг» /ажлын мэдлэг/ гэж тодорхойлжээ.

Л.Ф.Спирин чадварыг «автомат бус байдлаар гүйцэтгэх үйлдлийг эзэмшсэн байдал бус, харин мэдлэг дадлыг бүтээлчээр хэрэглэхийг хэлнэ»¹⁰ гэж үзсэн.

Ийм учраас мэргэжлийн үйл ажиллагааны явцад багш болох хүмүүсийг онол практикийн талаар бэлтгэх асуудлаар сэтгэл судлалын шинжлэх ухаанд бий болсон туршлага бидний судалгааны ажилд ихээхэн тустай юм. Ирээдүйн багш нарт мэргэжлийн чадварыг үр өгөөжтэй төлөвшүүлэхэд нөлөөлдөг нөхцөлийг илрүүлэх асуудал онцгой сонирхол татаж байна. Тиймээс харилцах чадвар багшийн харилцааны чухал элемент болдог. Ер нь харилцах чадварын төлөвшсөн байдлаар дамжиж бие хүний харилцах авьяас, түүний өвөрмөц чанар, зан төлөвийн шинж төгөлдөрждөг.

Багшаас суралцагчидтай харилцах үйл ажиллагааны өвөрмөц онцлог, агуулга, чадварын сэтгэл зүйн мөн чанарын талаар дээр авч үзсэн асуудал бид бүхэнд харилцах чадвар бол янз бүрийн үйл ажиллагааны нөхцөлд суралцагчидтай тогтоох сурган хүмүүжүүлэх зохимжтой уялдаа холбоог дэмжих, бий болгоход чиглэсэн багшаас практик үйлдлийн ба сэтгэцийн тогтолцоог эзэмших үйл гэж тодорхойлох үндэслэлийг олгож байна. Сурган хүмүүжүүлэх харилцаанд «үйлчилж байгаа» чадвар нь янз бүрийн мэргэжлийн багш, хүмүүжүүлэгчдэд ижилхэн шаардлагатай

⁸ Е.А.Милерян. Психология формирования общетрудовых политехнических умений. М., 1979. с.41

⁹ Ф.Н.Гоноболин. Психология. М., 1973. с.154

¹⁰ Л.Ф.Спирин. Формирование профессионально педагогических умений учителя-воспитателя. Ярославль, 1976. с.48

юм. Бидний судалж байгаа энэхүү чадварыг төлөвшүүлэх асуудал багшийн мэргэжилд чиглүүлэх ерөнхий бэлтгэлтэй холбоотой.

Хүүхэдтэй харилцахад багш, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс илрэх санаачилга, ач холбогдлыг Е.А.Милерян: «Багшийн харилцах чадвар нь сонсогчдын нөхцөл байдлын өөрчлөлтийг тооцох үндсэн дээр тулгуурлаж суралцагчдын анхаарлыг татах олон янзын арга барил, арга хэлбэрт тодорхой илэрдэг»¹¹ гэж заажээ.

Сэтгэл хөдлөлийн байдал нь аливаа үйл ажиллагаанд өвөрмөц суурь дэвсгэр болж, түүний үр дүнд ихээхэн нөлөө үзүүлдэг болох нь тодорхой юм.

Эрдэмтэн Н.Д.Левитов хүний сэтгэцийн байдлын талаарх асуудлыг судлаад «сэтгэлийн хөдөлгөөн ба мэдрэмжид хүний үйл ажиллагаа, сэтгэл санааны өвөрмөц ялгаа бүхий хандлага тод илэрдэг бөгөөд түүнд тодорхой хугацааны чиглэлийг өгч чанарын ялгаатай өвөрмөц сэтгэцийн өнгө төрх гэж нэрлэж болох үзэгдлийг бий болгодог»¹² гэж бичжээ.

Ийм учраас хүн үйл ажиллагааны эерэг үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ажлын байдалд оруулах, ажил явуулахад саад болж байгаа бодол санаа, сэтгэл хөдлөлөөс ангижрах чадвартай байх нь маш чухал.

Н.В.Кузьмина янз бүрийн түвшний үйл ажиллагааг харьцуулан судлаад харилцааны дараах чадварууд чухал болохыг онцлон тэмдэглэжээ. Үүнд: өөрийнхөө сэтгэлийн хөдөлгөөний байдлыг удирдах чадвар; хүүхдийн ертөнцийг хүртэх ойлгох чадвар; сэтгэл санаагаа хуваалцах чадвар¹³ гэх мэт. Н.В.Кузьмина өөр нэг бүтээлдээ эерэг сэтгэл санааны холбоо тогтоох чадвар; ажил хэрэгч ба сэтгэл санааны холбоо тогтоох дэмжих чадвар; хүүхдийн дотоод ертөнцөд орж харилцах чадвар; харилцаж буй үедээ харилцагч хүнээ сонсох, ойлгох чадвар; харилцагч хүнтэйгээ харилцан үйлдэл хийх чадвар; анги хамт олны сэтгэл санааны ерөнхий байдлыг тэнцвэртэйгээр хүртэн мэдрэх чадвар зэргийг ялгаж үзсэн байдаг.

Гэтэл Ф.Н.Гоноболин¹⁴ багшийн бие хүний сэтгэцийн шинж чанарт задлан шинжилгээ хийхдээ «хүүхдийн сэтгэцийн маш эмзэг нарийн ялгааг олж авах урлаг ба хүүхэдтэй үр өгөөжтэй харилцахад хэрэгтэй, ялангуяа, багшид зайлшгүй шаардлагатай чадвар бол бусад хүний нүдээр ертөнцийг харах чадвар юм» гэж онцлон тэмдэглэжээ. Багш сурган хүмүүжүүлэгчдэд

¹¹ Е.А.Милерян. Психология формирования общетрудовых политехнических умений. М., 1979. с.299

¹² Н.Д.Левитов. О психических состояниях человека. М., 1964. с.103

¹³ Н.В.Кузьмина. Очерки психологии труда учителя. Л., 1967. с.183

¹⁴ Ф.Н.Гоноболин О некоторых психических качествах личности учителя //Вопросы психологии. М.,1975. No1. С.100-110.

зайлшгүй шаардлагатай харилцааны чадварт А.А.Леонтьев¹⁵ дараах чадварыг хамааруулжээ. Үүнд: а) бие хүнээс өөрийнхөө онцлогийг иж бүрнээр хэрэглэх чадвар /өөрийгөө зориулах/; б) харилцаа тогтоох, үр эв дүйтэй холбоотой чадварууд

1. Өөрийн зан байдлыг удирдах чадвар;
2. Ажигламтгай байх чадвар;
3. «Хүний нүүр царайны илрэлийг таних» буюу социаль хүртэхүйн чадвар;
4. Зөвхөн харах биш ойлгох чадвар, өөрөөр хэлбэл, сурагчийг бие хүн, түүний сэтгэцийн байдал болон гадаад шинжээр нь загварчилна гэсэн үг;
5. Суралцагсадтай харилцахдаа бие сэтгэлээ зориулах чадвар;
6. Өөрийнхөө хэл яриаг сэтгэл зүйн хувьд оновчтой найруулж илэрхийлэх чадвар, өөрөөр хэлбэл, хэл ярианы харилцааны чадвар гэсэн үг.
7. Суралцагчидтай хэл ярианы ба хэл ярианы бус холбоо тогтоох чадвар гэх мэт.

Эдгээр чадварыг Л.С.Выготский өөрийнхөө бүтээлд бас дурдсан байдаг. Тэрээр үүнийг хүүхдийн сэтгэл санааг ойлгон түүнийг хамтран хуваалцаж, сэтгэл зүй оюун ухааныхаа туршлагаар тэдний дотоод нэвтрэн бодит харилцааны явцад цогц хэлбэрээр харилцан нөлөөлж багш өөрийгөө сурагчийн байр суурин дээр тавих чадвар гэж бичжээ.

В.А. Апполонов, С.В.Кондратьева, В.М.Раздобудько нарын судлаачид сурагчийн мэдрэмж бодол, санааг хамтран хуваалцаж түүний бие хүнийг тэнцвэртэйгээр ойлгох багшийн чадварыг сурган хүмүүжүүлэх харилцааны нийгэм-сэтгэл зүйн дэд бүрдэл хэмээн авч үзэж, тухайн чадвар нь суралцагчдын сургалтын материалд хандуулах сонирхлыг нь татах, хичээл дээр суралцагчдын сэтгэл санааны хариу үйлдлийг урьдчилан харах боломжийг олгож байдаг «түлхүүр» гэж цохон тэмдэглэжээ. Үүнээс гадна анги хамт олонтой сурган хүмүүжүүлэгч өөрийгөө сэтгэл санаагаараа ижилсүүлэн ойлгох чадвар нь сургалтын материал суралцагчдын хүмүүжил ба сургалтын аргыг сонгох хүүхдийн оюун санааны ертөнцөд сурган хүмүүжүүлэх нөлөөллийг шинжлэх ухааны үндэстэй зөв зохион байгуулах үндэс болдог.

Манай сурган хүмүүжүүлэгч, судлаач Ч.Түмэндэлгэр багшийн харилцааны өнгө аясыг товч томъёолж бичихдээ, анги дүүрэн харж чаддаг байх; хүүхдийн гадаад байдал, төрх, үйлдэл хөдөлгөөн, харц нүүрнээс нь «сэтгэлийг» нь «уншиж» чаддаг байх; хүүхдийн зан байдал сэтгэл санаанд сонор соргог хандах; хайхрамжгүй байдлыг цээрлэх; хичээлээс гадуур хүүхэдтэйгээ ойртон дотноших боломжийг ямагт эрж хайдаг байх зэрэг наад захын шаардлагыг мөрдөн

биелүүлэх нь зүйд нийцнэ»¹⁶ гэжээ.

Биехүний сэтгэцийн байдлын талаарх онолдээр тулгуурлаж сүүлийн үед судалгаа шинжилгээний ажил хийсэн Ю.П.Азаров, В.А.Кан-Калик, Ю.Л.Львова, Н.Д.Никандров, В.Н.Щербина нар сургалтын процессыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай багшийн дотоод төлөв байдлыг тодорхойлох ухагдахууныг бий болгосон байна. Тухайлбал, Ю.П.Азаров «бүтээлч догдлол» Ю.Л.Львова «ажлын бүтээлч мэдрэмж», В.А.Кан-Калик «бүтээлч өөрийн мэдрэхүй» гэх мэт.

В.А.Кан-Калик «бүтээлч өөрийн мэдрэхүйг» сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаан дахь мэргэжлийн маш чухал онцлог чанар гэж тодорхойлоод, сурган хүмүүжүүлэгчээс өөрийнхөө харилцаа, үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангахад шаардлагатай харилцааны чадваруудыг 3 бүлэгт нэгтгэн үзжээ.

Үүнд:

1. Хүмүүстэй харилцах чадвар;
2. Бий болсон харилцааны системээр дамжуулан суралцагчидтай хамтран хамтын бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулах чадвар;
3. Харилцааг чиглэл зорилготой зохион байгуулах, түүнийг удирдан хөтлөх чадвар /65,х.46/ орж байна.

Зарим нэгэн сурган хүмүүжүүлэх судалгааны бүтээлүүдэд харилцах чадварыг ангилах оролдлого хийсэн байдаг. Энэ нь бидний хийсэн судалгааны ажилд ихээхэн тус дөхөм үзүүлж байгаа юм. Судлаач Н.Н Страздас сургах тоглоомын тусламжтайгаар оюутан суралцагчдад харилцах чадварыг төлөвшүүлэх асуудлыг боловсруулахдаа дараах чадваруудыг ялган үзсэн байна. Үүнд:

1. Хичээл дээр биеэ авч явах чадвар /нүүрний хөдөлгөөн, анги дотор шилжих хөдөлгөөн хийх, биеийн ерөнхий байр байдал/;
2. Хэл ярианы эзэмшилт /хурц тод байдал, илэрхийлэл сайтай яруу байдал, сэтгэл хөдөлгөсөн байдал/;
3. Дуу хоолойны хувиралт, түүнийг эзэмшсэн байдал;
4. Мэдээллийн агуулгаар дамжуулан өөрийн сэтгэл санааг суралцагчдад хүргэж тэдэнд эерэг сэдэл бүрдүүлэх чадвар;
5. Суралцагчдад зан байдлын соёл төлөвшүүлэх чадвар;
6. Суралцагчдад хэл ярианы харилцааны явцад амьдрал ахуйн зан байдлыг төлөвшүүлэх чадвар;
7. Өөрийгөө үнэлэх ба хэсэгчилсэн үнэлгээг хэрэглэх чадвар
8. Суралцагчдад сургалтын явцад гаргасан өөрийнхөө амжилтыг өөрөө үнэлэх үйлийг төлөвшүүлэх багшийн өгсөн үнэлэлт дүгнэлтийн (дүнгийн) талаар эргэцүүлэн бодох

¹⁵ А.А.Леонтьев. Деятельность и общение //Вопросы философии. 1979.-№1, с.34.

¹⁶ Ч.Түмэндэлгэр. Сурган хүмүүжүүлэх харилцааны сэтгэл зүйн асуудалд//Боловсрол 1992. №1,2. х.85



үйлийг хөгжүүлэхэд өдөөх чадвар¹⁷ гэх мэт. Е.Б.Орлова судалгаандаа сурган хүмүүжүүлэх чадваруудыг зиндаачилж үзээд түүн дотроо бүлэг харилцах чадварыг ялган үзсэн байна:

1. Ажил руугаа чиглүүлсэн эерэг хандлагыг бий болгох чадвар;

2. Хичээлийн материалд татагдах сонирхол төрүүлэх чадвар;

3. Суралцагчидтай ажил хэргийн холбоо тогтоох чадвар;

4. Дотоод шалтгааны нөлөөгөөр үүсэх харилцааны чадвар;

5. Хүүхэдтэй сэтгэл санааны холбоо тогтоох чадвар;

6. Суралцагчдын хариу үйлдлийг урьдчилан харах чадвар¹⁸ гэх мэт.

Ийнхүү дээрх судалгааны бүтээлүүдэд харилцах чадварыг

- а) харилцаанд гүйцэтгэх үүргээр нь;
- б) сурган хүмүүжүүлэх авьяасын дэд бүрдлээр нь;
- в) багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны дэд бүтцээр нь;
- г) харилцааны гурван дэд бүрдэлт бүтцийн гол санаагаар ялгаж ангилсан байна.

Бид ангилалдаа, харилцах чадварын асуудлын талаарх ганц нэг, тархай бутархай төсөөллийг нэгтгэх, тэрчлэн багш сурагчдын харилцааны өвөрмөц онцлог шинж болох харилцан ярианы онцгой байр байдлыг тооцож үзэх шаардлагатай гэж үзсэн юм.

Энэ асуудлыг шийдээгүй байдал, болон судалгааны ажлын цаашдын зорилт (ирээдүйд багш болох хүний харилцах чадварын бүтцийг тогтоох) нь уг асуудалтай холбогдох бидний чиг хандлагыг зүй ёсоор гаргаж тавихыг шаардаж байна. Үүнийгээ бид дараах байдлаар авч үзэв.

Нийгмийн сэтгэл зүйд өргөн хэрэглэгддэг харилцааны гурван дэд бүрдэлт (В.Н.Мясищев, А.А.Бодалев нарын нийгмийн тусгал, сэтгэл санааны уялдаа холбоо, хандлагатай холбоотой гурван дэд бүрдэлт) концептуаль загвар; В.А.Кан-Каликийн сурган хүмүүжүүлэх харилцааны бүтцийн талаарх анализ; Г.М.Андреева, И.С.Тодорова, Б.Д.Парыгин нарын харилцан ярианы гүйцэтгэх үүрэг, ажиллагаа, онцлогт хийсэн судалгаан дээр тулгуурлаж бид харилцах чадварыг ангилан авч үзэж байна.

В.Н.Мясищев тухайн тохиолдолд «тусгал» хэмээх нэр томъёогоор «танин мэдэхүй», «харьцаа» гэдэгт сэтгэл санааны хариу үйлдлийн шинж чанар, харин «хандлага» гэдэгт харилцаанд илрэх хүний зан байдлын онцлогийг тодорхойлсон

байна¹⁹.

Үүнтэй уялдуулан, бид харилцах чадварыг гурван үндсэн дэд бүрдэлд хувааж тэдгээрийг ерөнхийд нь: 1) зан байдлын илэрхийлэл бүхий дэд бүрдэл; 2) хүртэж мэдрэхүйн дэд бүрдэл, 3) хичээл-судлагуунтай холбоотой дэд бүрдэл гэж нэрлэж байна.

1) Зан байдлын илэрхийлэл бүхий дэд бүрдэл. Энэ нь багшаас суралцагчидтай харилцан ярилцахад чиглэсэн үнэт зүйлийн баримжааллыг илрүүлэх, ажиллагааг шаардсан харилцааны нөхцөл байдал ба харилцах үйлийг зохион байгуулах чадвар, дадлаас бүрддэг. Энэ дэд бүрдэл нь дамжуулж байгаа болон- хүлээн авч байгаа мэдээлэлд, зааж байгаа хичээл юм уу эсвэл хэлэлцэж байгаа асуудалд хандах хэл ярианы бус хэрэгсэл, шууд байдлаар хандаж мэдээллийг дамжуулах чадвар багшид хэр зэрэг хөгжсөн байна вэ гэдгээр, түүнчлэн тэгш эрхтэй, бүрэн төгс харилцаа тогтоох, хамтран ажиллах ба бусдын үзэл бодлыг хүлээн авах чадвараараа суралцагчдыг өөртөө татах тийм хэрэгслийг хэр зэрэг эзэмшсэн байна вэ гэдгээр тодорхойлогдоно. Тухайн чадварын төлөвшлөөс багш-суралцагчдын харилцааны буцах холбоо ихээхэн хамаарна.

2) Харилцах чадварын хоёр дахь бүрдэл нь харилцаанд оролцогчдын харилцан үйлдлийн онцлог, харилцан ойлголт, харилцан нөлөөллийн уялдаа холбоо тогтоохтой холбоотой юм.

Энэ дэд бүрдлийн гол зүйл нь багшийн өөрийнх нь болон суралцагчдад хамаатай нийгэм-сэтгэлзүйн ба сэтгэцийн процесс, шинж байдал мөн. Тэрчлэн харилцааны нөхцөл байдлын онцлог чанар бас хамаарна. Уг дэд бүрдлийн чадвар төлөвшсөн байдлын шалгуурыг социаль хүртэхүйн хөгжил ямар түвшинд байна вэ гэдгээр нь ялган тогтоож болно. Үүнд, багшийн сэтгэл санаагаа хуваалцах чадвар (эмпати), өөрийгөө бусадтай ижилсүүлэн тавьж ойлгох чадвар (идентификаци) орно.

3). Харилцах чадварын гурав дахь дэд бүрдэл нь хичээл дээрх хадгалах, сэргээн санах үйлдлүүд буюу сургалтын процесстэй холбоотой юм.

Сургалтын материалд анализ хийх арга хэлбэр, түүнд шинжлэх ухаанч, бодитой байр сууринаас хандах хандлагыг багш ямар хэмжээгээр бүтээлч үйл ажиллагааны чадавх, диалектик сэтгэлгээг эзэмшсэн байна вэ гэдгээр гол төлөв тодорхойлно. Г.С.Батищев, В.С.Библер нар хувь хүний ухамсарт байгаа мэдлэг ухаан нь нэгдүгээрт, сэтгэн бодох үйл нь хаалттай, догматик хэлбэртэй; хоёрдугаарт, сэтгэн бодох үйл нь нээлттэй, учир шалтгааны уялдааг олж харсан хэлбэртэй байдаг [4, 5] гэжээ. Ийм учраас хоёр дахь хэлбэр нь үйлчилж байгаа тохиолдолд харилцан ярих харилцааны хэрэгцээ илэрдэг онцлогтой. Сургалтын материалтай холбогдуулан багшаас суралцагчидтай хийх

¹⁷ Н.Н.Страздас. Система дидактических игр как средство формирования педагогической умелости и направленности //Дис. канд.пед.наук.Л.,1980. с. 264

¹⁸Е.А.Орлова. Коммуникативные умения в структуре деятельности студентов на уроке в период педагогической практики: Автореф.дис.канд.психол. наук., 1971. с.18

¹⁹ В.Н. Мясищев.Личность и неврозы. Л., 1960. с.26

харилцан яриаг бий болгохын тулд, хичээл дээр ямар асуудал асуулт үүсэж болохыг урьдчилан харахын тулд, багш судлах зүйлээ олон талаас нь харсан байх шаардлагатай. Ер нь багш бол Дж.Гильфордын хэлснээр, «сэтгэхүйн уян хатан чанар, олон талаас ялгааг нь олж хардаг чанарыг» эзэмшсэн байх ёстой. Иймд энэ дэд бүрдлийг субъект-объектын харилцааны хүрээнд багшаас өөртэйгөө харилцах дотоод хэл ярианы онцлог тодорхойлдог.

Багшийн харилцах үйл ажиллагааны эдгээр дэд бүрдэл нь ерөнхий шинж чанартай бөгөөд тухайн судалгааны зорилгоос үүсэж байгаа билээ.

Харилцах чадварыг илэрхийлж байгаа энэ гурван дэд бүрдэл нь бодит харилцааны үйл явцад багшийн бие хүнийг цогц байдлаар харуулсан өвөрмөц хэлбэрийн хөгжил хөдөлгөөнийг бий болгодог. Ийм учраас харилцах чадварын тогтолцоог өв тэгш хөгжүүлж, иж бүрнээр төлөвшүүлэх асуудал нь багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сурган хүмүүжүүлэгчийг бэлтгэж байгаа үйл ажиллагаанд нэн шаардлагатайн зэрэгцээ багшлах боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгоход практикийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Багшийн харилцах чадварын асуудлаар бидний явуулсан судалгааны ажлын товч тойм нь харилцах чадварыг төлөвшүүлэх асуудалд задлан шинжилгээ хийхийг зүй ёсоор шаардаж байна. Ирээдүйд багш болох хүмүүсийг онол, практикийн хувьд бэлтгэх чухал асуудлын нэг бол харилцааг төлөвшүүлэх асуудал юм.

Сүүлийн үед оюутан суралцагчдад харилцах чадвар төлөвшүүлэх асуудлаар нэлээд олон тооны судалгаа хийжээ. Тухайлбал: А.А.Бондаренко, И.В.Лабутова нар сэтгэц хэл-шинжлэлийн агуулга талаас нь хичээл дээр багшийн харилцах үйл ажиллагааг боловсронгуй болгох; В.К.Елманова, Е.Б.Орлова, Л.А.Савенкова нар сурган хүмүүжүүлэх дадлагын явцад оюутан суралцагчдад харилцах чадвар төлөвшүүлэх; А.В.Фомин-багш оюутны хоорондын сурган-хүмүүжүүлэх харилцан үйлдлийн явцад харилцах чадварын гүйцэтгэх үүргийг илрүүлэх; А.В.Рыжов сурган хүмүүжүүлэх мэргэжилд бэлтгэх явцад оюутан суралцагчдын бие хүний шинж, харилцаа хоёрын хоорондын уялдаа холбоог илрүүлэх гэх мэт чиглэлээр судалжээ.

М.И.Плешкова бүтээлдээ²⁰ /28/, харилцах чадварыг хөгжмийн багш нарт чиглэл зорилготойгоор төлөвшүүлэх асуудлыг дэвшүүлж, дээд сургуулийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын явцад оюутан суралцагчдад харилцах чадварыг төлөвшүүлэх арга замыг авч үзжээ. Бидний үзэж байгаагаар, суралцагчдын сурах үйл ажиллагааны олон төрлийн-хэлбэрт харилцах чадварын ямар нэгэн үйлдэл, арга барилыг

²⁰ М.И.Плешкова. Формирование умений педагогического общения у студентов (на материале муз- пед.фак): Автореф. дис.канд.пед.наук. Киев. 1985. с.23

бэхжүүлэх, бий болгоход сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үйлдэлтэй ижил төстэй тийм нөхцөлийг харгалзан үзэх шаардлагатай юм.

Нэлээд олон тооны судалгааг [32, 9, 44, 45, 46, 26, 34, 43] сурган хүмүүжүүлэх арга хэмжээний тогтолцоог бий болгох, сурган хүмүүжүүлэх чадварыг төлөвшүүлэх, сурган хүмүүжүүлэх удирдлагын арга хэрэгслийг боловсруулах чиглэлээр хийсний дээр багш, суралцагчдад харилцах чадварыг төлөвшүүлэх үйл явцтай зэрэгцүүлэн судалж ирсэн байна. Харин эдгээр судалгааны ажлуудаас үзэхэд, харилцах чадвар бүрэлдэн төлөвших сэтгэл зүйн нөхцөл судлагдаагүй байгаа билээ.

Ирээдүйд багш болох хүмүүст мэргэжлийн чадварыг үр өгөөжтэйгөөр төлөвшүүлэхэд нөлөө үзүүлдэг хэд хэдэн нөхцөлийг мөрдлөг болгох шаардлагатайг судлаачид голлон анхаарч иржээ. Чадвар төлөвших үндсэн зүй тогтлыг дараах байдлаар авч үзэж байна. Үүнд:

- Сурган хүмүүжүүлэх чадвар нь мэдлэгийн систем дээр суурилж төлөвшинө;

Н.В.Кузьмина, Л.Ф.Спирин, О.А.Абдулина болон бусад судлаачдын үзсэнээр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэдлэг ухаан ба үйл ажиллагааны /судалж байгаа судлагдахууны талаарх мэдлэг/ агуулгын талаарх мэдлэг дээр суурилж сурган хүмүүжүүлэх чадвар төлөвшинө;

- Чадвар эзэмших процесст хүн өөрийнхөө хийж байгаа үйл ажиллагааны зорилго арга, барилын талаар мэдлэг эзэмших үйлийг ухамсарласан байх хэрэгтэй.

Арга судлалын гол зарчим нь сурах чадвараа ухамсарласан байх чанар юм. (Е.А.Милерян, Е.Н.Кабанова-Меллер, Н.Ф.Талызина).

- Ерөнхий ба тусгай чадвар төлөвших аливаа процессын зайлшгүй шаардлагатай нөхцөл нь онол, практикийн бэлтгэлийн уялдаа холбоо юм. (Б.Г.Ананьев, Е.А. Милерян)

- Сурган хүмүүжүүлэх чадварыг эзэмших, мэдлэг олж авахад чиглэсэн эерэг сэдлийг бий болгох хэрэгтэй;

- Аливаа чадвар нь өөрийнхөө хөгжлийн явцад хэд хэдэн үе шатыг дамждаг. Үүнд:

- ойр зуурын (анхдагч) чадвар-нэг их гаршаагүй үйл ажиллагаа

- тодорхой нэг ерөнхий чадвар

- өндөр хөгжсөн чадвар

- дээд зэргийн чадвар (мастерство).

Ийм байдлаар К.К. Платонов, Л.Ф.Спирин нарын судалгаанд авч үзсэн байдаг.

- Оюутан суралцагчдаас өөрийнхөө үйлдэлд анализ хийж хяналт тавих нь чадвар төлөвших чухал нөхцөл болдог. Үүнийг хэрэгжүүлэхдээ, суралцагчид чадварын хөгжлийн үе шат бүрт өөрийнхөө урагш ахих хөдөлгөөнд үнэлэлт өгч ухамсарлан, гаргасан алдаа дутагдлаа харах ёстой (В.А.Крутецкий);

- Сурган хүмүүжүүлэх авьяас, сурган



хүмүүжүүлэх чадвар өөр хоорондоо маш нарийн уялдаа холбоотой байдаг (В.А.Крутецкий, Н.В.Кузьмина).

- Чадвар төлөвших бас нэгэн чухал нөхцөлд сургалтын нөхцөл байдлын олон хувилбарт чанар (Е.А.Милерян), операцийн шилжилт дээр суурилсан чадвар эзэмших үйл ажиллагааны нөхцөл нарийн түвэгтэй болох процесс (Д.Н.Богоявленский, Е.А.Кабанова-Меллер, Н.Н. Менчинская, С.Л.Рубинштейн болон бусад) ордог. Энэ шилжилт, шинж тэмдгээрээ нөхцөлтэй ижил төсөөтэй байдалд тулгуурладаг учраас үйл ажиллагааны зорилгод маш чухал юм (Г.С.Костюк, А.В.Петровский болон бусад).

Дээр дурдсан нөхцөлүүд тусгайлан боловсруулсан дидактик хэрэгслээр дамжин бүрэлдэж бий болдог. Тухайлбал, багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг загварчилсан сургалтын даалгавар, дасгал сургууль гэх мэт. Ирээдүйд багш болох хүмүүст харилцах чадварыг төлөвшүүлэх хэрэгслийн нэг нь мэргэжлийн үйл ажиллагаанд бэлтгэх нийгэм, сэтгэл зүйн идэвхтэй арга болох нийгэм сэтгэл зүйн-тренинг юм. Нийгэм сэтгэл зүйн-тренинг өөртөө хэд хэдэн аргыг иж бүрнээр нь агуулсан байдаг. Үүнд хамаарах уламжлалт аргуудаас дурдвал: лекц, яриа, семинар, кино, нийгэм сэтгэл зүйн бүтээлүүдийг судлах гэх мэт. Харин идэвхтэй аргад: хэсэг бүлгийн маргаан, дүрийн тоглолт, сензитив тренинг (АНУ-ын сэтгэл зүйч К.Роджерс анх удаа хэрэглэсэн), видео тренинг, зан байдлын тренинг хамаарна. Эдгээр аргад сургах, оношлох, хянах гэсэн гурван үндсэн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд ямар нэгэн хэмжээгээр харилцааны техникийг эрчимтэй эзэмших зорилтыг шийдвэрлэдэг. Л.А.Петровская нийгэм-сэтгэл зүйн тренингийн гол ноён нуруу болсон асуудал нь харилцааны субъект-субъектын хэлбэр, харилцан яриаг хэрэгжүүлэх явдал мөн гэж тэмдэглэсэн байдаг²¹.

Сургуулийн сургалт хүмүүжлийн явцад нэлээд хүчтэй илэрч байгаа багш, сурагч гэсэн уламжлалт тогтолцоонд бий болсон эзэн биегүй байдлыг арилгахад илүү зохимжтой, боловсронгуй ардчилсан хэлбэрийг хангахад харилцан яриа бүхий хэв шинжийг нэвтрүүлэх асуудал чухал юм. Сургуулийн сургалт хүмүүжлийн практикаас ч ийм хэрэгцээ үүсэж байгаа юм. Иймд нийгэм-сэтгэл зүйн тренингийн үндсэн дээр тусгайлан боловсруулсан даалгавар хийлгэх замаар ирээдүйд багш болох суралцагчдад харилцах чадварыг төлөвшүүлэх нь илүү зохимжтой гэж бид үзэж байна²².

Харилцах чадвар төлөвших ерөнхий зүй тогтлыг тооцон үзэж, мэргэжлийн чадварыг үр

²¹ Т.С.Яценко Об одном подходе к пониманию психологических механизмов и динамики группового обучения педагогическому общению //АМОПО и его оптимизации /Под ред. А.А. Бодалева.-М.: АПН СССР.1983. с.110

²² Санжмятав. Ч. Багшийн харилцах чадвар, түүнийг төлөвшүүлэх сурган хүмүүжүүлэх сэтгэл зүйн үндэс. Уб.,1997

дүнтэйгээр эзэмшихэд дөхөмтэй тийм нөхцөл байдлыг бий болгож, багш бэлтгэдэг сургуулиудад мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөөнд эрс өөрчлөлт оруулахгүйгээр, сурган хүмүүжүүлэх дадлагыг боловсронгуй болгох замаар харилцах чадварыг төлөвшүүлэх асуудлыг шийдэж болох юм.

Судалгааны ажлын зорилготой уялдуулан, суралцагчдад харилцах чадварыг амжилттай төлөвшүүлэх үйлийг тодорхойлогч сэтгэл зүйн хүчин зүйлийг авч үзэх шаардлага урган гарч байна. Судалгааны ажилд тавьсан зорилтыг шийдвэрлэх хэсэг рүү орохын өмнө судалгаанд хэрэглэх үндсэн ойлголтыг тодорхойлон авч үзье! Үүнтэй холбогдуулан, бидний судалгааны ажлын зорилго, зорилттой ижил төстэй гэж үзэж байгаа В.Г. Леонтьевын²³ судалгааны ажлын үндсэн хэсэг дээр тогтож дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай юм. В.Г.Леонтьев бие хүний хөгжлийн хүчин зүйлийн талаар цохон тэмдэглэхдээ: «1. Хэрэв процессын үйл ажиллагаа гэж үзэж байгаа бол энэ процесс явагдах хүчин зүйл нь нөхцөл хэлбэрээр оролцоно. 2. Хэрэв процессын өөрчлөлтийн талаар ярьж байгаа бол хүчин зүйл нь энэ өөрчлөлтийн шалтгаан болж ойлгогдоно. 3. Хэрэв процессыг хөгжил гэж үзэж байгаа бол хүчин зүйл нь түүнийг хөдөлгөгч хүч болно» гэж бичсэн байдаг.

Бид судалгааныхаа ажилд харилцах чадварыг төлөвшүүлэх үйлийг тодорхойлогч хүчин зүйл нь чадварын бүрэлдэн төлөвших нөхцөл мөн гэж ойлгож тэр талаас нь авч үзэж байгаа юм.

Харилцааг тодорхойлогч хүчин зүйлийг өргөн утгаар нь авч үзэж ангилахдаа объектив, субъектив, гадаад, дотоод хүчин зүйлд хуваасан байдаг.

Ер нь «гадаад хүчин зүйл» гэсэн ойлголтыг «бодит хүчин зүйлтэй», «дотоод хүчин зүйл»-ийг «субъектив хүчин зүйлтэй» ижилсүүлэн авч үзсэн тал бий. Хэд хэдэн судалгаанд эдгээр ойлголтыг зааглан үзсэн байдаг. Тухайлбал; Е.В.Цуконова «харилцааг зохион байгуулах өвөрмөц онцлогийг процесс гэж үзэж задлан шинжлээд, харилцааны явц агуулга талыг бүрэлдүүлж байдаг тэр процесс механизмыг дотоод хүчин зүйл, харин харилцаанд оролцогчдын хувийн сэтгэл зүйн онцлогийг харуулж байгаа бүлэг бодгаль хүчин зүйлсийг гадаад хүчин зүйл» гэж үзжээ²⁴.

Энэ хоёр бүлэг хүчин зүйл хоорондоо маш нарийн уялдаа холбоотой байдаг.

Бидний судалгааны ажилд авч үзэж байгаагаар, объектив хүчин зүйл нь (нийгэм-сэтгэл зүйн тренингийн үндсэн дээр хөгжүүлэх шинж чанартай, тусгайлан боловсруулсан даалгаврыг онол практикийн бэлтгэлд нь тусгаж явуулсан сургалт- хүмүүжлийн дадлага ажил)

²³ Исследование мотивационной сферы личности/Отв. ред.В.Г.Леонтьев. Новосибирск 1984. с.163

²⁴ Е.В.Цуконова.Психологические трудности межличностного общения. Киев.1985.с.38

харилцах чадварыг төлөвшүүлэх тодорхой нөхцөл юм. Харин субъектив нөхцөл нь бид бүхний судалж байгаа харилцах чадварыг амжилттай төлөвшүүлэх үйлийг хурдасгах юмуу эсвэл удаашруулах хүчин зүйл болох суралцагчдын бие хүний шинж болж байна.

Харилцаанд нөлөөлдөг хүчин зүйлийг судалсан туршилт судалгааны бүтээлүүдээс үзэхэд, нэг хэсэгт нь харилцаа ямар нэгэн хүчин зүйлтэй уялдан холбогдсон байдаг болохыг тогтоож илрүүлсэн байхад, нөгөө хэсэгт нь тийм уялдаа холбоог илрүүлээгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, уялдаа холбооны сөрөг шинж чанар илэрсэн байна. Үүнийг В.С.Мерлин бүтээлдээ: «эдгээр зүйл нь өөр хоорондоо олон утгатайгаар холбогдож байгаа бөгөөд энэхүү уялдаа холбооны шинж чанар шалтгаалах ямар нэгэн дам тусгал бүхий нөхцөл оршиж байгааг харуулж байгаа юм»²⁵ гэжээ. Жишээ болгож С.В.Кондратьева өөрийнхөө бүтээлд бичсэнийг дурдъя. Тэрээр бичихдээ, «Хүнийг гүнзгий ойлгох, түүнд хүнлэг сэтгэлээр хандах явдал нь хүн бүрээс харилцааны арга хэлбэрийг олж авах чадвар төлөвших нэг нөхцөл болдог»²⁶ гэжээ.

Мэдээж хэрэг, сурган хүмүүжүүлэх мэдлэг, чадвар, дадал бүрэлдэн төлөвших үндэс нь сурган хүмүүжүүлэх авьяас болдог билээ. Бидний үзэж байгаагаар бол, харилцах чадварыг бүрэлдүүлэн төлөвшүүлэх үндэс болсон сурган хүмүүжүүлэх авьяас нь харилцах, хүртэн мэдрэх чадвар юм. Харин дотоод хүчин зүйл нь социаль хүртэхүй мөн.

Хүртэн мэдрэх авьяас чадварыг хүүхэд бие хүн болж хөгжих чиг хандлага, боломж чадавхи болон тодорхой нөхцөлд хүүхдийн сэтгэлийн байдал, хүүхдийг ойлгох, оновчтой хүртэн мэдрэх үйлээр тодорхойлно. Судалгааны ажлын үр дүнд харилцах чадварыг бид ангилж үзсэн тухайгаа дээр өгүүлсэн билээ. Ийм учраас хүртэж мэдрэх дэд бүрдлийн үндэс нь хүртэн мэдрэх авьяас болж байна. Энэ нь манай судалгааны ажлын зорилго, зорилттой нийцэж байгаа хэрэг. Хүртэн мэдрэх авьяаст дараах чадварууд хамаарна. Үүнд:

- Суралцагчдын бие хүнийг бүхэлд нь хүртэн мэдрэх чадвар;
- Тодорхой нөхцөл байдал, хувийн болон насны онцлогийг харгалзан өгөөжтэй нөлөөллийн арга хэмжээг сонгож авах, суралцагчдын зан төлөвийн гадаад илрэлээс ирж байгаа "сэтгэл зүйн дохиог" зөв тайлж танин мэдэх чадвар;
- Суралцагчдын зан төлөвийн бодит сэдэл шалтгаан дээр чиглэн баримжаалах чадвар гэх мэт.

А.А.Кидрон харилцах чадвар нь өргөн утгаараа харилцааны талаар өргөн мэдлэгтэй байх чанартай нэгэн ижил утгатай гэж тодорхойлсон байдаг.

²⁵ В.С.Мерлин.Очерк интегрального исследования индивидуальности. М.,1986. с.28

²⁶ С.В.Кондратьева Межличностное понимание, его роль в общении: Автореф.дис. докт.психол.наук. Л., 1976. с.3

А.А.Кидрон харилцах чадварын бүтцийг хувийн, зан байдлын, танин мэдэхүйн буюу үнэлгээний гэсэн гурван түвшинд авч үзсэн. Н.В.Кузьмина сурган хүмүүжүүлэх авьяасын ерөнхий бүтцийн дотор харилцах чадварыг ялгаж үзсэн байдаг бөгөөд энэ нь «хүүхэдтэй зөв боловсон харьцаа холбоо тогтоох, түүнийгээ суралцагчдын хөгжил хөдөлгөөн, тэднээс тавигдах шаардлагатай уялдуулан өөрчлөх чадвар болно»²⁷ гэж тодорхойлсон байдаг. Харилцах авьяас нь зан байдлын илэрхийлэл бүхий дэд бүрдэл, хичээл-судлахуунтай холбоотой дэд бүрдлийн чадварыг хөгжүүлэхэд маш чухал нөлөөтэй. Бид судалгааныхаа ажилд харилцах чадвар, хүртэн мэдрэх авьяасын хоорондын уялдаа холбоог илрүүлэх оролдлого хийж байгаа юм.

Харилцах чадвар төлөвшихөд хүчтэй нөлөө үзүүлдэг өөр нэг сэтгэл зүйн хүчин зүйл бол идентификаци юм. Нийгмийн сэтгэл судлалын салбар ухаанд «объекттой өөрийнхөө ямар нэгэн ижил төстөй байдлыг субъект шууд мэдрэх ба бодгаль хүн өөрийгөө бусад хүнтэй ижилсүүлэхийг» идентификаци²⁸ гэж тодорхойлсон байдаг. Зөвхөн өөрийнхөө бодгаль хүний байр байдлыг анхаараад зогсохгүй, харин сурагчийн байр байдлаас эргэцүүлэн бодох, шүүн хэлэлцэх мэтгэлцэн маргахад голлон тэмүүлэх, сонирхох чадвартай багш, сурагчаас өөрийнхөө байр байдлыг гаргахад нөлөөлөх, өдөөх, сонирхол төрүүлэх сэтгэл зүйн нөхцөлийг бий болгодог.

Багшийг сэтгэл зүйн хувьд бэлтгэх үйл ажиллагаа, бие хүмүүсийн хоорондын харьцаа, сурган хүмүүжүүлэх үйл явцад эмпацийн /сэтгэл санаагаа илэрхийлж бусдын байр сууринд өөрийгөө тавих чадвар/ гүйцэтгэх үүргийг судалсан хэсэг эрдэмтдийн хийсэн анализ дүгнэлтээс үзэхэд, суралцагчдын анги хамт олныг бүхэлд нь юм уу эсвэл сурагчийн сэтгэл санааны ерөнхий байдал мэдрэмжийг ойлгох, сэтгэл санаагаа харилцан илэрхийлэх, хамтран хуваалцах, зовлон жаргалаа хуваалцах чадвар, багшийн мэргэжлийн маш чухал чанар болох нь илэрч байна.

Өмнө өгүүлснийг нэгтгэн дүгнэж үзвэл, харилцах чадвар амжилттай эзэмшихэд нөлөө үзүүлдэг тийм хүчин зүйлийг оюутан суралцагчдад байгаа эмпацийн хөгжлийн түвшин гэж үзэж байна.

Т.В.Аргентова, И.А.Межлумова нарын зэрэг олон судлаач²⁹ бие хүний ерөнхий чиглэл зорилгот чанараас хамаарч багшаас өөрийгөө үнэлэх үнэлгээг, нэг талаас, сэтгэл санааны

²⁷ Н.В.Кузьмина. Очерки психологии труда учителя. Л., 1967. с.136

²⁸ Психологический словарь /Под ред. В.Б.Давыдова, А.В.Запорожина, Б.Ф.Ломова и др. НИИ ОПП СССР, М., 1983. с.122

²⁹ Т.В.Аргентова. Стиль общения как фактор эффективности совместной деятельности: Автореф. дис. канд. психол. наук. М.,1984. с.20



тогтвортой байдал, нейротизм, түгшүүрт чанар зэрэг бие хүний чанарууд, нөгөө талаас, сургалтын ажлын үндсэн стратегийг сонгож авах сонголт тодорхойлно гэж үзсэн байдаг.

Сурган хүмүүжүүлэх дадлагын үед оюутан суралцагчдад харилцах чадвар төлөвшүүлэх процесс юуны түрүүнд тэд нарт харилцах чадварын хэрэгцээг үүсгэхээр үйл ажиллагааг нь зохион байгуулах шаардлагатай бөгөөд энэ нь тэдний хувьд үйл ажиллагааны зорилго болох ёстой.

Нэрт сэтгэл зүйч А.Н.Леонтьев «сэдлээс шалтгаалж түүнтэй холбогдож байгаа зорилго, үйл ажиллагаанд бодгаль хүний хувьд өөр өөр утга санаатай болдог»³⁰ гэж бичсэн байдаг. Сэдлийн цогц, нэгдмэл шинж чанар, онцлогийн талаар хийсэн сэтгэл зүйчдийн олон тооны судалгаа түүнийг тодорхойлогч үндсэн үзүүлэлтийг сэдлийн олон шалтгаант чанар үе шатлалт чанарт байна гэж тогтоожээ. Энэ баримт дээр тулгуурлан сэдлийг Е.А.Климовын хэлсэнээр «утга санааг бүрдүүлэгч сэдэл ба ноёлох сэдэл гэж ялган үзэж болно. Энэ нь сурах үйл ажиллагааны ерөнхий чиг хандлага, харилцааны системд түүний эзлэх байр суурийг» тодорхойлдог.

Ирээдүйд багш болох суралцагчдад тийм утга санааг бүрдүүлэгч сэдэл нь сурган хүмүүжүүлэх харилцааны чадварыг амжилттай эзэмших чанарыг голлон тодорхойлогч мэргэжлийн сэдэл болох ёстой гэж бид үзэж байгаа юм.

Харилцааг тодорхойлогч хүчин зүйлийн талаар явуулсан цаашдын задлан шинжилгээний ажлаас үзэхэд, харилцаа, бие хүний чанарын хооронд маш нарийн бөгөөд олон тооны уялдаа холбоо байдаг болох нь илэрч байна. Харилцааны явцад бие хүний онцлог нөлөөлдөг зарим тохиолдлыг авч үзээд Е.В.Цуконова, экстраверсийн хүчин зүйлийн нөлөөгөөр өөр хоорондоо шилжих харилцан ярианы бүтцийн сэлгээ буюу харилцааны явцад дисинхронизаци үүсдэг болохыг цохон тэмдэглэсэн байдаг. Тэрээр «нейротизмын хүчин зүйл нь сэтгэцийн таатай байдлын түвшнийг бууруулж зан байдлыг тэнцвэргүй байдалд оруулдаг ба харилцааны хэл ярианы бус хэрэгслийг хэрэглэх үед дотоод шалтгааны улмаас бий болох чадварт нөлөөлдөг»³¹ гэж бичжээ.

Судлаачид тодорхой шинж чанарын нөлөөллийг цохон тэмдэглэхийн чацуу, харилцаанд бие хүний цогц бүрдлийн үзүүлэх нөлөөллийг дурдсан байдаг. Тухайлбал, Т.С.Яценко тэмдэглэхдээ «уян хатан чанаргүй багш бол зөрчил маргааныг улам бадрааж дотоод зөрчилтэй байдлыг улам хүчтэй болгож, сэтгэц мэдрэлийн дарамтаас гарах чадварыг багасгадаг»³² гэжээ. Энэ нь суралцагчидтай

харилцах харилцаанд хүүхдэд сөрөг нөлөөтэй хэтэрхий хэрээс хэтэрсэн хатуу шаардлага тавих явдлаар илэрч болно.

Дээр дурдсан судалгааны бүтээлд хийсэн анализ, харилцааны олон талт нарийн түвэгтэй нэгдмэл цогц онцлог байдал зэргээс үндэслэн суралцагчдын харилцах чадварын төлөвшил нь харилцаанд нөлөө үзүүлж байдаг бүхэл бүтэн гадаад дотоод объектив, субъектив хүчин зүйлсийн нөлөөлөл мөн гэсэн дүгнэлт хийж болох юм. Бид судалгаандаа харилцан ярианы мөн чанарт нөлөөтэй тэр хэсгийг нь сонгож авсан бөгөөд харилцааг судалсан тэдгээр бүтээлүүдийн үр дүнг хүлээн зөвшөөрч байна. Ингэж судалгааны асуудалд онолын анализ хийсний үр дүнд харилцах чадвар төлөвших сэтгэл зүйн хэд хэдэн нөхцөлийг таамаглал болгон дэвшүүлж ялган авч үзэх боломжтой боллоо. Үүнд: 1. багшийн харилцах чадварын бүтцийн талаарх төсөөлөл ба мэдлэгийн төгс төгөлдөр байдал; 2. харилцах чадварыг эзэмших сурган хүмүүжүүлэх мэргэжлийн чиглэл зорилгот чанар; 3. түүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн эерэг идэвхтэй хандлага; 4. чадвар төлөвших үе шатууд хөгжил хөдөлгөөнийг /динамикийг/ ухамсарласан байдал; 5. Суралцагчдын харилцаатай холбоотой бие хүний чанар; 6. эмпати, идентификацийн хөгжлийн түвшин; 7. харилцах, хүртэн мэдрэх авьчас чадварын хөгжлийн түвшин.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Түмэндэлгэр, Ч. (1992). Сурган хүмүүжүүлэх харилцааны сэтгэл зүйн асуудалд. *Боловсрол*, 1, 2, 82-88
- Абдулина, О.А. (1980). *Общепедагогическая подготовка учителя в системе педагогического образования*. Москва
- Андреева, Г.М. (1980). *Социальная психология*. Москва
- Аргентова, Т.В. (1984). *Стиль общения как фактор эффективности совместной деятельности: Автореф, дис. канд. психол. наук*. Москва
- Батищев, Г.С. (1963). *Противоречие как категория диалектической логики*. Высшая школа. Москва
- Библер, В.С. (1975). *Мышление как творчество; Введение в логику мысленного диалога*. Политиздат Москва
- Бодалев, А.А. (1970). *Формирование понятия о другом человеке как личности*. Ленинград
- Гоноболлин, Ф.Н. (1973). *Психология*. Просв-е. Москва
- Гоноболлин, Ф.Н. (1975). *О некоторых психических качествах личности учителя. Вопросы*

³⁰ А.А.Леонтьев Педагогическое общение. М., 1979, с.9

³¹ Е.В.Цуконова. Психологические трудности межличностного общения. Киев, 1985.147с.

³² Яценко Т.С. Об одном подходе к пониманию

психологических механизмов и динамики группового обучения педагогическому общению // АМОПО и его оптимизации /Под ред. А.А. Бодалева.-М.: АПН СССР.1983. С.82.

- психологии, 1, 100-110.
- Елманова, В.К. (1975). О коммуникативных умениях студентов. *Теоретические и прикладные проблемы психологии познания людьми друг друга*. Краснодар
- Редактор, Леонтьев, В.Г.(Ред). (1984). *Исследование мотивационной сферы личности*. Новосибирск
- Кан-Калик, В.А.(1987). *Учителю о педагогическом общении: Книга для учителя*. Москва
- Кондратьева, С.В.(1976). Межличностное понимание, его роль в общении: *Автореф.дис. докт. психол.наук*. Ленинград
- Кузьмина, Н.В. (1967). *Очерки психологии труда учителя*. Ленинград
- Кузьмина Н.В., Кухаренко, Н.В. (1979). *Психологическая структура деятельности учителя* (тексты-лекции). Гомель
- Кузьмина, Н.В.(1980). *Методы системного педагогического исследования: Учебное пособие*. Ленинград
- Левитов, Н.Д.(1964). *О психических состояниях человека*. Москва
- Леонтьев, А.А.(1979). Деятельность и общение // *Вопросы философии*, 1, 121- 132.
- Леонтьев, А.А.(1979). *Педагогическое общение. Знание*. Москва
- Леонтьев, А.Н.(1972). *Проблемы развития психики*. Москва
- Ломов, Б.Ф. (1979). Категории общения и деятельность в психологии. *Вопросы философии*, 8, 34-47
- Межлумова, И.А., Сухобкая, Г.С. (1977). Изучение профессиональной направленности личности учителя (в сфере общения). *Проблемы высшего педагогического образования*.
- Мерлин, В.С. (1986). Очерк интегрального исследования индивидуальности. *Педагогика*. Москва
- Милерян, Е.А. (1979). *Психология труда и профессионального образования*. Москва.
- Мясищев, В.Н. (1960). *Личность и неврозы*. Ленинград
- Мясищев, В.Н. (1970). О взаимосвязи общения, отношения и обращения как проблема общей и социальной психологии. *Социально-психологические характеристики форм общения и развитие контактов между людьми*. Ленинград
- Нормативные предписания к разработчикам и пользователям психодиагностических методик. *Вопросы психологии*. (1987), 5, 176-181.
- Орлова, Е.А. (1971). *Коммуникативные умения в структуре деятельности студентов на уроке в период педагогической практики*, Автореф. дис. канд. психол. наук. Ленинград
- Платонов, К.К. (1962). *Вопросы психологии труда*. Москва
- Плешкова, М.И.(1985). *Формирование умений педагогического общения у студентов* (на материале муз-пед.фак): Автореф. дис.канд.пед.наук. Киев
- Редактор, В.Б.Давыдова А.В.Запорожина, Б.Ф.Ломова и др. (Ред). (1983). *Психологический словарь*. НИИ ОПП СССР М.:Педагогика.
- Раздобудько, В.М. (1973). *Понимание учителем личности учащихся*: Автореф. дис. канд. психол.наук. Киев
- Санжмятав, Ч. (1997). *Багшийн харилцах чадвар, түүнийг төлөвшүүлэх сурган хүмүүжүүлэх сэтгэл зүйн үндэс*. Улаанбаатар
- Сластенин Б.А. (1976). *Формирование личности учителя советской школы в процессе профессиональной подготовки*. Прос-е. Москва
- Спирин, Л.Ф. (1976). *Формирование профессионально педагогических умений учителя-воспитателя*. Ярославль
- Страздас, Н.Н. (1980). *Система дидактических игр как средство формирования педагогической умелости и направленности* //Дис.канд.пед.наук, 264. Ленинград
- Страхов, И.В. (1980). *Психология педагогического общения. Методические разработки для преподавателей и студентов*. Саратов
- Фомин, А.В. (1978). *Роль коммуникативных умений в процессе педагогического взаимодействия преподавателя со студентами*: Автореф.дисс. канд. пед. наук. Ленинград



- Цуконова, Е.В. (1985). *Психологические трудности межличностного общения*. Киев
- Щербаков, А.И. (1967). *Психологические основы формирования личности советского учителя в системе высшего педагогического образования*. Ленинград
- Щербаков, А.И. (1976). *О методологии и методике изучения психологии труда и личности учителя*. Ленинград
- Щербаков, А.И. (1980). Психолого-педагогическая подготовка учителя-воспитателя и пути ее оптимизации, Под ред. А.И.Щербакова, *Проблемы совершенствования системы психолого-педагогической подготовки учителя*. Ленинград
- Яценко, Т.С. (1983). Об одном подходе к пониманию психологических механизмов и динамики группового обучения педагогическому общению, Под ред. А.А. Бодалева. *АМОПО и его оптимизации*. Москва. АПН СССР
- Carl, R. Rogers.(1969). Freedom to learn: a view of what education might become. *Columbus*. Ohio
- Carl, R. Rogers, C. (1972). The process of the basic encounter group. In: Cathcart, R.S., Samovar, L.A.(edc). *Small group communication*. New York
- Carl, R. Rogers. (1975). *Encounter group*. London